



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/126

Улаанбаатар хот

Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 09 дугаар сарын 05-ны өдрийн 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хэй Ли Сиэф Мото Монголиа” ХХК-аас нийгмийн хариуцлагын хүрээнд тус хэлтсийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор хандивласан нийт 9,800,000.00 (есөн сая найман зуун мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс (Ч.Мөнхбаатар)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс (Ч.Мөнхбаатар)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В. Оюунмаа* В. ОЮУМАА





Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
 даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ны
 өдрийн А.У.С. дугаар тушаалын хавсралт

Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалт ад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ /төгрөгөөр/		Хөрөнгө оруулалтын шийдвэр болон хандивлагчийн нэр	Хөрөнгийн эх үүсвэр
							нэгжийн үнэ	нийт дүн		
Тоног төхөөрөмж										
1	Цахилгаан дугуй		2025 он	шинэ	ш	1	9,800,000.00	9,800,000.00	"Хэй Ли Сизф Мото Монголиа" ХХК	Хандив
	Дүн					1		9,800,000		
								9,800,000.00		
Нийт дүн										